



**“ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ  
(9, 10, 11, 16, 20, 21, 22, 23 ДУГААР ХОРОО)”-ЫН ДААЛГАВАР**

2024 оны 01 дүгээр сарын 23

Дугаар *24/25*

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол</li> <li>- Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/16 дугаар захирамж</li> </ul>
2	Байршил, хүчин чадал	<ul style="list-style-type: none"> <li>- Дүүргийн 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23 дугаар хороод</li> <li>- 12-15м өндөртэй, 8ш шон</li> <li>- 200 Ватт хүчин чадалтай /8 талт/ гэрэлтүүлэг</li> </ul>
3	Төсөл боловсруулах үе шат, хугацаа	<p><u>2 үе шаттай.</u></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын зураг, төсөв боловсруулж магадлал хийлгэх</li> <li>2. Батлагдсан зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх</li> </ol> <p>/Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно./</p>
4	Төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага</li> </ul>
5	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> <li>- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар</li> </ul>
6	Төслийн санхүүжилт	<ul style="list-style-type: none"> <li>- Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт</li> </ul>
7	Төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Одоогийн байдлын судалгаа</li> <li>- Ажлын зураг</li> <li>- Төсөв</li> <li>- Магадлалын дүгнэлт</li> <li>- Тайлбар бичиг</li> </ul> <p>Бусад холбогдох материалууд</p>
8	Эдийн засгийн тооцоо, төсөв	<p>Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.</p>
9	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Хууль тогтоомж:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Эрчим хүчний тухай хууль</li> </ul> <p>Норм, дүрэм:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43.101.03</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02</li> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-10-04/</li> <li>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08</li> <li>- Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх БД 30-102-11</li> </ul>

		<p>Стандартууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэрэлтүүлэх төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага UCS 1901B</li> <li>- Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж UCS1902A</li> </ul> <p>Бусад холбогдох норм, дүрэм, стандартууд</p>
10	Инженерийн хангамж	<ul style="list-style-type: none"> <li>- Техникийн нөхцөлд тавигдсан шаардлагын дагуу олон улсын чанарын стандарт хангасан тоног төхөөрөмж кабель шугам материалыг сонгох</li> <li>- Цахилгаан хангамжийн шугамд одоо холбогдож байгаа хэрэглэгч ба хэтийн төлөвлөлтөөр хэрэглэгчдийг холбох боломжийг бүрдүүлж өгөх</li> <li>- Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдана</li> <li>- Шинээр төлөвлөгдөх гэрэлтүүлгүүдийн удирдлагын цит нь Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төвийн хяналтад байдаг гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлагын Тулга системд холбогдоно.</li> </ul>
11	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа орчныг судалж, зураг, төсөв дээр ашиглагч байгууллага, захиалагчтай зөвшилцөх</li> <li>- Хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн норм дүрмийн дагуу онцлох хэв маягийг тусгаж өгөх</li> <li>- Цахилгааны шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх</li> <li>- Төлөвлөж буй цахилгаан хангамжийн шугам сүлжээнд одоо холбогдсон болон төлөвлөлтөөр холбогдох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх</li> <li>- Ойр орчмын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч компаниудын цахилгаан хангамжийн трасстай уялдуулан төлөвлөсөн байх</li> <li>- Шугам сүлжээний хамгаалалтын зайг баримтлах</li> <li>- Эрчим хүчний хэмнэлттэй лед гэрэлтүүлэгч сонгоно</li> <li>- Инженерийн хангамжийн асуудлыг тооцоо, судалгааны үндсэн дээр хийх</li> <li>- Инженерийн шугам сүлжээ, нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт, зөөж, шилжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлын зураг төсөв боловсруулах</li> </ul>

ХЯНАСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.ЭНХЦЭНГЭЛ

ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Т.МӨНХ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:  
ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН АЖИЛТАН

 М.ЭХТҮВШИН